ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2022/116/-НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582  Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463  Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Уваа Уул Аудит ХХК

Захирал: Ч.Мөнхтуяа

Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

## Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....14
3. Аудитын тайлан.....15
3.1 Ерөнхий зүйл.....15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....16
3.4 Материаллаг байдал.....16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....18
3.8 Аудитын гол асуудал.....18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....19
4. Аудитын илрүүлэлт.....20
4.1 Залруулсан алдаа.....20
4.2 Албан шаардлага.....20
4.3 Зөвлөмж.....20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....21

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УБЕГ | Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| НХМ | Нэг хэвийн маягт |
| ТБОНӨТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272248, Факс: 70272582 И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/123

танай ____________ -ны № ____________ -т

ТӨВ АЙМГИЙН БАЯНДЭЛГЭР
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Г.УЯНГА ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

19020390

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **40,535,175.40** | **107,302,732.41** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **0.00** | **10,261,515.00** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **0.00** | **10,261,515.00** |
| **31210** | **Төгрөг** | **0.00** | **10,261,515.00** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 10,261,515.00 |
| **33** | **АВЛАГА** | **0.00** | **57,353,000.00** |
| **33500** | **Бусад авлага** | **0.00** | **57,353,000.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 0.00 | 57,353,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **40,535,175.40** | **39,688,217.41** |
| **35100** | **Түүхий эд материал** | **11,144,488.40** | **6,013,778.60** |
| 35130 | Эм боох материал | 11,144,488.40 | 6,013,778.60 |
| **35400** | **Хангамжийн материал** | **28,820,687.00** | **33,224,438.81** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 328,900.00 | 374,050.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 19,246,655.00 | 15,736,409.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,164,382.42 | 238,755.03 |
| 35450 | Барилгын засварын материал | 96,200.00 | 0.00 |
| 35460 | Хүнсний материал | 623,465.58 | 972,901.58 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,361,084.00 | 15,902,323.20 |
| 35600 | Мал амьтад | 570,000.00 | 450,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **219,905,354.58** | **233,823,888.23** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **219,905,354.58** | **233,823,888.23** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **196,329,354.58** | **210,247,888.23** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 154,118,053.30 | 154,118,053.30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (14,275,252.52) | (21,737,878.76) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 58,447,500.00 | 31,910,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (52,147,166.63) | (31,627,666.83) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 107,280,478.97 | 136,388,209.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (61,653,409.70) | (64,842,124.19) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 11,296,014.75 | 12,923,972.58 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,040,319.59) | (8,359,677.67) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 2,225,000.00 | 2,225,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | (375,000.00) | (750,000.00) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 453,456.00 | 0.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **23,576,000.00** | **23,576,000.00** |
| 39301 | Програм хангамж | 446,950.00 | 446,950.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (446,950.00) | (446,950.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 23,576,000.00 | 23,576,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **260,440,529.98** | **341,126,620.64** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **10,746,313.07** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **0.00** | **10,746,313.07** |
| **41300** | **Өглөг** | **0.00** | **10,746,313.07** |
| **41360** | **Бусад өглөг** | **0.00** | **10,746,313.07** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 10,746,313.07 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **260,440,529.98** | **330,380,307.57** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **260,440,529.98** | **330,380,307.57** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 95,376,537.48 | 95,376,537.48 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **32,913,600.85** | **104,691,817.19** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 42,422,623.82 | 34,752,039.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | -9,509,022.97 | 69,939,777.59 |

| | | | |
|---|---|---|---|
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 132,150,391.65 | 130,311,952.90 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **260,440,529.98** | **341,126,620.64** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **329,602,401.66** | **621,216,678.68** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **14,855,030.66** | **142,826,295.68** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **14,855,030.66** | **142,826,295.68** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 0.00 | 33,639,307.56 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 14,855,030.66 | 109,186,988.12 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **314,747,371.00** | **478,390,383.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **255,829,600.00** | **300,097,300.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 255,829,600.00 | 300,097,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **4,303,997.00** | **71,253,155.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,303,997.00 | 69,996,155.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 1,257,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **41,446,400.00** | **41,541,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 41,446,400.00 | 41,541,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **13,167,374.00** | **65,498,128.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 13,167,374.00 | 65,498,128.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **339,111,424.63** | **551,276,901.09** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **339,111,424.63** | **551,276,901.09** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **338,723,552.03** | **549,299,062.09** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **205,772,198.53** | **241,819,449.05** |
| 210101 | Үндсэн цалин | 141,229,399.48 | 160,896,728.67 |
| 210102 | Нэмэгдэл | 46,162,599.34 | 56,200,723.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,899,999.75 | 24,406,163.83 |
| 210104 | Урамшуулал | 15,480,199.96 | 315,832.89 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **27,365,354.87** | **27,938,993.95** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,255,654.87 | 19,065,628.58 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,027,200.00 | 1,826,601.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,622,700.00 | 2,976,572.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 405,400.00 | 455,837.38 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,054,400.00 | 3,614,354.34 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **39,827,305.00** | **39,421,961.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,285,768.00 | 2,890,962.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,535,537.00 | 36,530,999.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,000.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,881,218.80** | **20,947,643.19** |
| 210401 | Бичиг хэрэг | 711,300.00 | 1,005,650.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,984,718.80 | 15,335,627.39 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 900,000.00 | 900,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,285,200.00 | 3,706,365.80 |
| **2105** | **Нормативт зардал** | **20,857,227.86** | **118,532,149.52** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 18,716,590.86 | 109,828,079.52 |
| 210502 | Хоол, хүнс | 2,140,637.00 | 8,704,070.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,381,500.00** | **958,200.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,600.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,363,900.00 | 958,200.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **848,500.00** | **670,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 848,500.00 | 670,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **589,978.00** | **0.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,500.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 0.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 243,478.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **30,200,268.97** | **99,010,165.38** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,078,250.80 | 72,036,197.47 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 27,122,018.17 | 26,973,967.91 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **387,872.60** | **1,977,839.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **0.00** | **1,008,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 1,008,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **376,395.00** | **0.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 372,895.00 | 0.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 3,500.00 | 0.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **11,477.60** | **969,839.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,477.60 | 969,839.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-9,509,022.97** | **69,939,777.59** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-9,509,022.97** | **69,939,777.59** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **95,376,537.48** | **132,150,391.65** | **42,422,623.82** | **269,949,552.95** |
| **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **95,376,537.48** | **132,150,391.65** | **42,422,623.82** | **269,949,552.95** |
| **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **(9,509,022.97)** | **(9,509,022.97)** |
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **95,376,537.48** | **132,150,391.65** | **32,913,600.85** | **260,440,529.98** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 1,838,438.75 | 1,838,438.75 |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **95,376,537.48** | **132,150,391.65** | **34,752,039.60** | **262,278,968.73** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | (1,838,438.75) | 0.00 | (1,838,438.75) |
| Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 69,939,777.59 | 69,939,777.59 |
| **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **95,376,537.48** | **130,311,952.90** | **104,691,817.19** | **330,380,307.57** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **314,747,371.00** | **421,037,383.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **0.00** | **77,420.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **0.00** | **77,420.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **0.00** | **77,420.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 77,420.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **314,747,371.00** | **420,959,963.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **255,829,600.00** | **300,097,300.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 255,829,600.00 | 300,097,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **4,303,997.00** | **71,253,155.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,303,997.00 | 69,996,155.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 1,257,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **41,446,400.00** | **41,541,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 41,446,400.00 | 41,541,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **13,167,374.00** | **8,067,708.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 13,167,374.00 | 8,067,708.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **312,447,371.00** | **408,965,868.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **312,447,371.00** | **408,965,868.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **312,059,498.40** | **406,988,029.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **205,772,198.53** | **243,714,353.45** |
| 210101 | Үндсэн цалин | 141,229,399.48 | 160,896,728.67 |
| 210102 | Нэмэгдэл | 46,162,599.34 | 56,181,822.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2,899,999.75 | 26,319,969.23 |
| 210104 | Урамшуулал | 15,480,199.96 | 315,832.89 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **27,365,354.87** | **26,044,089.55** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,255,654.87 | 17,324,089.55 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,027,200.00 | 2,179,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,622,700.00 | 1,743,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 405,400.00 | 435,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,054,400.00 | 4,360,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **39,827,305.00** | **39,421,961.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,285,768.00 | 2,890,962.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,535,537.00 | 36,530,999.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,000.00 | 0.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **13,784,500.00** | **16,810,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,085,000.00 | 13,110,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 900,000.00 | 900,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,799,500.00 | 1,800,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **14,790,289.20** | **34,911,894.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,515,889.20 | 29,202,337.00 |
| 210502 | Хоол, хүнс | 2,274,400.00 | 5,709,557.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **5,198,422.00** | **5,890,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 457,122.00 | 1,240,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,495,100.00 | 3,500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,246,200.00 | 1,150,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **848,500.00** | **382,500.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 848,500.00 | 382,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,589,978.00** | **0.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,022,500.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 0.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 243,478.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,882,950.80** | **39,813,231.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,882,950.80 | 39,813,231.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **387,872.60** | **1,977,839.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **0.00** | **1,008,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 1,008,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **376,395.00** | **0.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 372,895.00 | 0.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 3,500.00 | 0.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **11,477.60** | **969,839.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 11,477.60 | 969,839.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **2,300,000.00** | **12,071,515.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **2,300,000.00** | **1,810,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,300,000.00** | **1,810,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **2,300,000.00** | **1,810,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,300,000.00 | 1,810,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-2,300,000.00** | **-1,810,000.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **0.00** | **10,261,515.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 10,261,515.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **356,684,000.00** | **338,552,874.00** | **18,131,126.00** | 94.9 |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **356,684,000.00** | **338,552,874.00** | **18,131,126.00** | 94.9 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **356,684,000.00** | **338,552,874.00** | **18,131,126.00** | 94.9 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **235,720,700.00** | **230,800,339.45** | **4,920,360.55** | 97.9 |
| Үндсэн цалин | 155,157,500.00 | 147,982,714.67 | **7,174,785.33** | 95.4 |
| Нэмэгдэл | 52,753,600.00 | 56,181,822.66 | **(3,428,222.66)** | 106.5 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 27,809,600.00 | 26,319,969.23 | **1,489,630.77** | 94.6 |
| Урамшуулал | 0 | 315,832.89 | **-315,832.89** | |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **31,822,300.00** | **24,300,697.55** | **7,521,602.45** | 76.4 |
| Тэтгэврийн даатгал | 22,393,500.00 | 15,580,697.55 | **6,812,802.45** | 69.6 |
| Тэтгэмжийн даатгал | 2,357,200.00 | 2,179,700.00 | **177,500.00** | 92.5 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1,885,800.00 | 1,743,800.00 | **142,000.00** | 92.5 |
| Ажилгүйдлийн даатгал | 471,400.00 | 435,900.00 | **35,500.00** | 92.5 |
| Эрүүл мэндийн даатгал | 4,714,400.00 | 4,360,600.00 | **353,800.00** | 92.5 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **40,391,800.00** | **39,421,961.00** | **969,839.00** | 97.6 |
| Гэрэл, цахилгаан | 3,555,200.00 | 2,890,962.00 | **664,238.00** | 81.3 |
| Түлш, халаалт | 36,538,100.00 | 36,530,999.00 | **7,101.00** | 100.0 |
| Цэвэр, бохир ус | 298,500.00 | 0 | **298,500.00** | - |
| **Хангамж, бараа материалын зардал** | **16,810,000.00** | **16,810,000.00** | **0.00** | 100.0 |
| Бичиг хэрэг | 1,000,000.00 | 1,000,000.00 | **0.00** | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 13,110,000.00 | 13,110,000.00 | **0.00** | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 900,000.00 | 900,000.00 | **0.00** | 100.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,800,000.00 | 1,800,000.00 | **0.00** | 100.0 |
| **Нормативт зардал** | **18,889,200.00** | **14,787,800.00** | **4,101,400.00** | 78.3 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 11,889,200.00 | 11,889,200.00 | **0.00** | 100.0 |
| Хоол, хүнс | 7,000,000.00 | 2,898,600.00 | **4,101,400.00** | 41.4 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **6,650,000.00** | **6,650,000.00** | **0.00** | 100.0 |
| Багаж, техник, хэрэгсэл | 2,000,000.00 | 2,000,000.00 | **0.00** | 100.0 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,500,000.00 | 3,500,000.00 | **0.00** | 100.0 |
| Урсгал засвар | 1,150,000.00 | 1,150,000.00 | **0.00** | 100.0 |
| **Томилолт, зочны зардал** | **1,000,000.00** | **382,500.00** | **617,500.00** | 38.3 |
| Дотоод албан томилолт | 1,000,000.00 | 382,500.00 | **617,500.00** | 38.3 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **5,400,000.00** | **5,399,576.00** | **424.00** | 100.0 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 5,400,000.00 | 5,399,576.00 | **424.00** | 100.0 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **356,684,000.00** | **349,784,228.00** | **6,899,772.00** | 98.1 |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **300,097,300.00** | **341,639,100.00** | **41,541,800.00)** | 113.8 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 300,097,300.00 | 300,097,300.00 | **0.00** | 100.0 |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **41,541,800.00** | 41,541,800.00 | **41,541,800.00** | - |
| Орон нутгийн төсвөөс | 41,541,800.00 | 41,541,800.00 | **41,541,800.00** | - |
| **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **15,044,900.00** | **8,067,708.00** | **6,977,192.00** | 53.6 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 15,044,900.00 | 8,067,708.00 | **6,977,192.00** | 53.6 |
| **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **0** | **77,420.00** | **(77,420.00)** | |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0 | 77,420.00 | **(77,420.00)** | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 | **0.00** | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 10,261,515.0 | 10,261,515.0 | |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* *\/төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **71,253,155.00** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **71,253,155.00** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 70,245,155.00 |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 12,914,014.00 |
| Үндсэн цалин | 12,914,014.00 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,743,392.00 |
| Тэтгэврийн даатгал | 1,743,392.00 |
| **Нормативт зардал** | 20,124,094.00 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 17,313,137.00 |
| Хоол, хүнс | 2,810,957.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,050,000.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | 1,050,000.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 34,413,655.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 34,413,655.00 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,008,000.00 |
| **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | - |
| Засгийн газрын гадаад шилжүүлэг | - |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 1,008,000.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,008,000.00 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 71,253,155.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 71,253,155.00 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 69,996,155.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,257,000.00 |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн ашиглах жилийг сунгах, тооллогын бүртгэл, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-аас 2022 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Уваа уул Аудит ХХК-ийн аудитор Б.Буяндэлгэр, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанар хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Уваа уул аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв нь Эрүүл мэндийн тухай хуулийн 16.4 дэх заалт, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх чиг үүрэгтэй бүхий үйл ажиллагаа явуулдаг Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаал "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар Төв аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 339,111.4 мянган төгрөгөөс 1,0 хувиар буюу 3,391.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,373.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Зуунмод сумын Хүмүүн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 300,097.3 мянган төгрөгийн санхүүжилтийг, орон нутгийн төсвөөс 41,541.8 мянга, ЭМДГ-аас санхүүжилт 8,145.1 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан байна

Нэмэлт санхүүжилтийн дансанд 71,253.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Мөнгөн гүйлгээний тайлангаар нийт 69,996.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд 37,345.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4,000.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 1,780.0 мянган төгрөг нийт 41,345.9 мянган төгрөгийн хөрөнгийн орлого бүртгэж, тайлагнаснаас төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 1,810.0 мянган төгрөгийн, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 39,535.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд хандиваар 102,852.3 мянган төгрөгийн, төсвийн хөрөнгөөр 81,721.1 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, 185,420.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

***Авлага, өглөгийн талаар*:**

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 57,353.0 мянган төгрөгийн авлага, 10,746.3 мянган төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

***Санхүүгийн байдлын тайлангийн талаар:***

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 39,688.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 233,823.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 10,261.5 | 10,261.5 |
| Авлага | 0.0 | 57,353.0 | 57,353.0 |
| Бараа материал | 40,535.2 | 39,688.2 | (847.0) |
| Үндсэн хөрөнгө | 219,05.4 | 233,823.9 | 13,918.5 |
| Нийт хөрөнгө | **260,440.5** | **341,126.6** | 80,686.1 |
| Өглөг | 0.0 | 10,746.3 | 10,746.3 |
| ЗГ-н оруулсан капитал | 95,376.5 | 95,376.5 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 32,913.6 | 104,691.8 | 71,778.2 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | **260,440.5** | **341,126.6** | 80,686.1 |

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 10,261.5 мянган төгрөг байгаа нь Сангийн яамнаас ЭМЯ-ны харьяа байгууллагуудын улсын төсөв, нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг татан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
- Авлага дансны үлдэгдэл 57,353.0 мянган төгрөгөөр өссөн нь ЭМДС-аас авах авлагаас шалтгаалсан байна. Эрүүл мэндийн байгууллагууд ЭМДС-аас гүйцэтгэлээр санхүүждэг болсноос үүдэн гарсан авлага байна.
- Бараа материалын дансанд үнэ төлбөргүй хүлээн авсан эм боох материалын дансанд Эрүүл мэндийн газраас төгрөгийн 82,665.2 мянган төгрөгийн вакцин авсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны өөрчлөлт: Төсвийн хөрөнгөөр 1,810 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Төв аймгийн Эрүүл мэндийн газраас 4,789.3 мянган, аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс хандив тусламжаар 33,634.5 мянган төгрөгийн хөрөнгө тус тус орлогод авснаас шалтгаалсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус Эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 301,125.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 41,541.8 мянган төгрөг, ЭМДСангаас 63,314.7 мянган төгрөг үүнээс урсгал зардалд 405,982.0 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 49,298.0 мянган төгрөгөөр бууруулан 356,684.0 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээнд орон нутгийн төсвөөс 41,541.8 мянга, ЭМДСангаас 63,314.7, улсын төсвөөс 251,827.5 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 235,570.8 мянга, орон нутгийн төсвөөс 41,541.8 мянган төгрөг, ЭМДСангаас 63,314.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 346,620.6 мянган төгрөгийг зарцуулж, 10,063.4 мянган төгрөгийг үлдэгдэлтэй гарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 346,620.6 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь хандив тусламжийн орлого 6,977.2 мянган төгрөгөөр орлого дутуу, цалин хөлсний зардлыг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг дутуу зарцуулснаас голлон шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар дээд шатны төсөв захирагчаас эм, эмнэлгийн зардалд 69,996.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого болох ковидын шинжилгээний орлого 1,257.0 мянга нийт 71,253.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-н зардалд 14,657.4 мянган, Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд 17,313.1 мянган, Эд хогшил, урсгал засварын зардалд 1,050.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 34,413.7 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд эмнэлгийн үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 117.2 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 97.2 хувийн биелэлттэй байна.

**3.8 Аудитын гол асуудал**

Хэвтэн эмчлүүлэгчийн тусламж үйлчилгээ, амбулаторийн тусламж үйлчилгээ болон оношилгоо шинжилгээний тусламж үйлчилгээ буурч зөвхөн ковидын тусламж үйлчилгээ үзүүлснээс үүдэн ЭМДС-аас авах санхүүжилт 6,977.2 мянган төгрөгөөр буурсан байна.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 347,743.0 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 6 мэдээллийг хугацаа хоцроосон, 49,476.0 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл"-ийн дагуу шалгахад шалгагдагч байгууллага нь Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу төсвийн гүйцэтгэлийн тайлангаа бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төсвийн гүйцэтгэлийн тайлангаа иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй, хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 54.5, Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.4 дэх заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байгааг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 142,826.3 мянган төгрөгийн 4 алдаа зөрчилд 142,826.3 мянган төгрөгийн 1 алдааг залруулан, залруулаагүй алдааг зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- 120017, 120018 дансанд бүртгэх ёстой 142,826.3 мянган төгрөгийн орлогыг 1200045 дансанд бүртгэсэнд залруулга хийлгэв.

### 4.2 Албан шаардлага

Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 347,743.0 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 6 мэдээллийг хугацаа хоцроосон, 49,476.0 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээлэл байршуулсан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага өгөв.

### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. *Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 39,045.2 мянган төгрөгийн хөрөнгө байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох“ тогтоолын 7.1-д “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

ТӨБЗГ-н тогтоолын хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн ашиглах жил, үнийг шинэчлэн тогтоох, зөрчлийг давтан гаргахгүй байх

**2. *Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

*Илрүүлэлт:*

Үндсэн хөрөнгийн тооллогын баримтад эд хариуцагчийг карт, тооллогын комиссын илтгэх хуудас, өмч хамгаалах зөвлөлийн тэмдэглэл, байгууллагын удирдлагад танилцуулсан тэмдэглэл, тооллогын баталгаа хийгдээгүй зэрэг нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д. “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй...”, 72 дугаар зүйлийн 72.4-д “Тооллогын комисс дараах үүрэгтэй...” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн аудитын “үнэлгээ ба хуваарилалт”, “тохиолдсон байх”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Тооллогыг ажлыг чанартай явуулж холбогдох хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Төв аймгийн Баяндэлгэр сумын Эрүүл мэндийн төв | 4 | 142,826.3 | 1 | 142,826.3 | | | 1 | - | 2 | - |
| | ДҮН | 4 | 142,826.3 | 1 | 142,826.3 | | | 1 | - | 2 | |